



# ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ᠳᠣᠷᠨᠣᠭᠣᠪᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ  
ᠨᠢᠶᠢᠭᠦᠮ, ᠡᠳᠢᠶᠢᠨ ᠵᠠᠰᠭᠢᠨ  
ᠲᠠᠨᠢᠯᠴᠠᠭᠤᠯᠠᠭ᠎ᠠ  
ᠲᠡᠭᠦᠨ

## ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

# 2019/12



Мэдээллийн нэгдсэн лавлах: [WWW.1212.MN](http://WWW.1212.MN)



## ГАРЧИГ

Товч танилцуулга.....	1-19
Нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд.....	20
Нэг. Хүн ам.....	21-22
Хоёр. Эрүүл мэнд.....	23-25
Гурав. Боловсрол, соёл.....	26
Дөрөв. Хөдөлмөр эрхлэлт .....	27-29
Тав. Нийгмийн даатгал, халамж.....	30-33
Зургаа. Гэмт хэрэг.....	34-35
Долоо. Дотоодын нийт бүтээгдэхүүн .....	36
Найм. Мөнгө, зээл.....	37
Ес. Төсөв, санхүү .....	38-39
Арав. Үнэ .....	40-45
Арван нэг. Хөдөө аж ахуй.....	46-56
Арван хоёр. Аж үйлдвэр .....	57-62
Арван гурав. Тээвэр, холбоо.....	63-64
Арван дөрөв. Байгаль орчин .....	65

---

## **ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**

( 2019 оны 12 дугаар сарын байдлаар)

### **Нэг. Нийгмийн үзүүлэлт**




#### **1.1 Хүн ам**

2019 оны урьдчилсан дүнгээр 71.0 мянган хүн амтай болж 2018 оны жилийн эцсийн хүн амын мэдээнээс 2.0 хувиар буюу 1415 хүнээр өссөн байна. Даланжаргалан, Өргөн, Сайхандулаан, Улаанбадрах, Хөвсгөл, Сайншанд, Замын-Үүд сумдад хүн амын тоо 0.2-4.5 хувиар өсч, бусад сумдад буурсан үзүүлэлт гарчээ.

Дорноговь аймгийн хүн амын тоонд насны ангилал тус бүрийн эзлэх хувийн жин 2018 онд 2010 оныхоос өөрчлөгдсөн байна. 2010 онд хүн амын 29.6 хувийг хүүхэд (0-14нас), 65.6 хувийг хөдөлмөрийн насны (15-64нас), 4.8 хувийг тэтгэврийн насны хүн ам эзэлж байсан бол 2019 онд 31.6 хувийг хүүхэд, 61.9 хувийг хөдөлмөрийн насны, 6.4 хувийг тэтгэвэрийн насны хүн ам эзлэж байна. 2010 оны хүн амын орон сууцны тооллогын дүнтэй хүн амын тоонд насны ангилал тус бүрийн эзлэх хувийн жинг харьцуулахад 0-14 насны хүүхэд 2.0 пунктээр, тэтгэврийн насны хүн ам 1.6 пунктээр тус тус нэмэгдэж, хөдөлмөрийн насны хүн ам 3.7 пунктээр буурсан байна.

*Зураг. Хүн амын тоо, өсөлтийн хувь, жил бүрийн эцэст*




#### **1.2 Өрхийн зарим үзүүлэлт**

Өрх, хүн амын нийгмийн зарим үзүүлэлтийг 2018 онтой харьцуулахад гэр бүлгүй эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн тоо 13.0 хувиар, өрх толгойлсон эрэгтэйчүүдийн тоо 15.8 хувиар, 2 ихэр хүүхэдтэй өрхийн тоо 0.9 хувиар, ганц биеэрээ амьдарч байгаа өндөр настан өрхийн тоо 3.4 хувиар, тэтгэвэр тэтгэмж тогтоогдоогүй ахмад настай хүний тоо 35.0 хувиар тус тус буурсан байна.

Өнчин хүүхдийн тоо 2019 онд 851 болж 2018 оноос 17-оор буюу 2.0 хувиар өсчээ. Нийт өнчин хүүхдийн 6.3 хувь буюу 54 нь бүтэн өнчин, 93.7 хувь буюу 797 нь хагас өнчин хүүхдүүд юм.

Зураг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, 2016-2019 он



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо 2642 болж өмнөх оныхоос 83(3.2)-аар нэмэгдлээ. Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 7.9 хувийг 0-14 насны хүүхэд эзэлж байгаа бол 33.4 хувь нь төрөлхийн, 66.6 хувь нь өвчнөөр болон осол гэмтлийн улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон байна.




### 1.3 Эрүүл мэнд

Дорноговь аймгийн хэмжээнд 2019 оны 12 сард 1351 эх амаржиж, 1358 хүүхэд шинээр мэндэлж, 399 хүн нас барсан байна. Амаржсан эхийн тоо өмнөх оны мөн үеэс 14(1.0%)-өөр, төрсөн хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 40(0.9%)-өөр тус тус буурч, нас барсан хүний тоо өмнөх оны мөн үетэй адил хэмжээнд байна.


Хүн амын цэвэр өсөлт 959 болж 2018 оны мөн үеийнхээс 10(1.0%)-аар тус тус буурсан байна. 1000 хүнд ногдох төрөлт 19.3, нас баралт 5.7 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 1.0 пунктээр, нас баралт 0.1 пунктээр тус тус буурсан байна.

2019 онд 411.0 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 16.2 хувиар, 17.4 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 2.6 хувиар, 13.3 мянган хүн урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан нь өмнөх оноос 1.5 хувиар тус тус өсчээ.

Зураг. Урьдчилан сэргийлэх тарилга, мян.хүн



Зураг. Амбулаторийн үзлэг, мян.хүн




Энэ онд 1811 эх жирэмсний хяналтанд орсны 88.6 хувь буюу 1604 эх жирэмсний эхний 3-н сард хяналтанд хамрагджээ.

Түргэн тусламжийн дуудлага 20.1 мянган удаа гарсны 2.9 мянга буюу 14.4 хувь нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт түргэн тусламжийн дуудлага 2.0 хувиар өсч, алсын дуудлага 6.5 хувиар буурсан байна.

Он гарсаар ослын улмаас 3376 хүн бэртэж, 97 иргэний амь нас энджээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал ослын улмаас бэртсэн хүний тоо 11.9 хувиар өсч, нас барсан хүний тоо 9.3 буурчээ.

Зураг. Нас баралт, өвчний шалтгаанаар, хувь. 2019 оны 12 сард



Нас баралтыг өвчний шалтгаанаар авч үзэхэд осол нэмтэл, хордлого гадны шалтгаант үхэл 24.3 хувь, хавдар 22.6 хувь, цусны эргэлтийн тогтолцооны өвчин 22.6 хувь, бусад төрлийн өвчин 15.8 хувь, амьсгалын тогтолцооны өвчин 7.8 хувь, хоол шингээх эрхтний өвчин 7.0 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт өвчний 1119 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 382-оор буюу 51.8 хувиар өсчээ. Халдварт өвчний тохиолдол өсөхөд заг хүйтэн 62.0 хувь, трихоминиаз 70.2 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.



#### 1.4 Боловсрол

2019/2020 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 22 сургуульд 13971, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Төмөр замын мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 755, АШУҮИС-д 475 бүгд 15201 оюутан, сурагч суралцаж байна. Энэ нь өмнөх оноос 7.4 хувиар буюу 1049-өөр илүү байна.

2019/2020 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангид 1655, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуульд 90, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Төмөр замын мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төвд 560 оюутан, сурагч шинээр элсэн суралцлаа.



#### 1.5 Соёл

Аймгийн соёл урлагын байгууллагууд 2019 онд 33.0 мянган хүнд үйлчилж, 55696.0 мянган төгрөгийн орлоготой ажиллажээ. Аймагт үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн урлагийн байгууллага 166 удаагийн тоглолт хийж, музейнүүд дотоод, гадаадын 5.5 мянган хүнд үйлчилсэн байна.




#### 1.6 Бүртгэлтэй ажилгүй иргэн

Хөдөлмөрийн хэлтэст ажил хайж бүртгүүлсэн иргэд 2019 оны эцэст 300 болсны 249 (83.0%) нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 51 (17.0%) нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд нь өмнөх оны мөн үеийнхээс 693 (69.8%) хүнээр буурч, өмнөх сараас 126 (42.0%) хүнээр өсч, 300 болсны 144 (48.0%) нь эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 165 (55.0%) нь Сайншанд суманд, 65 (21.7%) нь Замын-Үүд суманд байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн боловсролын түвшинг харахад 178 (59.3%) нь бүрэн дунд, 55 (18.3%) нь дээд, 24 (8.0%) нь техник болон мэргэжлийн, 18 (6.0%) нь бүрэн бус дунд, 16 (5.3%) нь тусгай дунд, 6 (2.0%) нь бага, 2 (0.7%) нь боловсролгүй, 1.0 (0.3%) нь магистр/докторын зэрэгтэй иргэд эзэлж байна.


Зураг. Ажилгүй иргэдийн тоо, боловсролоор, хувиар, 2019 оны эцэст



Хөдөлмөрийн хэлтэст 2019 оны эцэст 2421 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 1088 иргэн ажилд зуучлагдан орж, 2219 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна.

Хөдөлмөрийн хэлтэст ирсэн 1321 ажлын байрны 655 (49.6%) нь энгийн ажил, 255 (19.3%) нь техникч болон туслах / дэд мэргэжилтэн, 106 (8.0%) нь худалдаа, үйлчилгээний ажилтан, 101 (7.6%) нь мэргэжилтэн, 85 (6.4%) нь суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч, 54 (4.1%) нь үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний, 32 (2.4%) нь контор үйлчилгээ, 15 (1.1%) нь хөдөө аж ахуй, ой загас агнуурын ажилтан, 11 (0.8%) нь менежер, 7 (0.5%) нь зэвсэгт хүчний ажил мэргэжилийн захиалга байна.

Зураг. Бүртгэлгүй ажилгүй иргэд сумаар      Зураг. Шинээр ажлын байранд орсон иргэд салбараар




Ажил хайгч 1088 иргэн ажилд зуучлагдан орсоны 439 (40.3%) нь эмэгтэйчүүд байна.



### 1.7 Нийгмийн даатгал, халамж


Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2019 оны байдлаар 42158.7 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 8443.9 (25.0%) сая төгрөгөөр өссөн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого 2019 онд өмнөх оны мөн үеэс 8443.9 сая төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн даатгал 5404.0 (25.5%) сая төгрөг, эрүүл мэндийн даатгал 1287.8 (23.1%), ҮОМШӨ-ний даатгал 893.2 (25.3%) сая төгрөг, тэтгэмжийн даатгал 612.4 (25.4%) сая төгрөг, ажилгүйдлийн даатгал 246.5 (25.1%) сая төгрөгөөр өссөн байна.

Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого сангийн төрлөөр /сая.төг/ 2019 оны эцэст



Нийгмийн даатгалын сангийн зарлага 51537.1 сая.төг болж өмнөх оны мөн үеэс 6089.6(13.4%) сая.төгрөгөөр өссөн байна. Зарлагыг бүтцээр нь авч үзвэл тэтгэврийн даатгалын сангаас 38297.2 (74.3%) сая.төг, эрүүл мэндийн даатгалын сангаас 6122.6 (11.9%) сая.төг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 3151.5 (6.1%) сая.төг, тэтгэмжийн даатгалын сангаас 2880.39 (5.6%) сая.төг, ажилгүйдлийн даатгалын сангаас 1084.9 (2.1%) сая төгрөгийг зарцуулжээ.



**Зураг. Нийгмийн даатгалын орлого, зарлага, сараар, сая төг**



Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр нийгмийн халамжийн сангаас 2019 онд нийгмийн халамжийн сангаас 32195 иргэнд 8779.6 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгожээ. Өмнөх онтой харьцуулахад халамж авсан иргэд 1525 (5.0%)-оор өсч, олгосон тэтгэвэр тэтгэмж 715.5 (8.9%) сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2019 онд 1471 хүн хамрагдсан нь өмнөх оноос 95 (6.9%)-өөр өсч, олгосон тэтгэвэрийн хэмжээ 293.3 (12.6%) сая төгрөгөөр нэмэгджээ.

Нийгмийн нөхцөлт мөнгөн тусламжийг 1176 иргэнд 888.2 сая төгрөг, онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг 1138 иргэнд 717.2 сая төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг 115 иргэнд 27.9 сая төгрөг тус тус олгож, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай НХТХууль 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургахад 16206 иргэнийг хамруулж, 1424.4 сая төгрөгийг зарцуулсан байна. Бусад төрлийн халамжийн үйлчилгээнд 12089 иргэн хамрагдаж, 3106.3 сая төгрөгийг олгожээ.

**Зураг. Хүний тоо**



Зураг. Олгосон тэтгэвэр, тэтгэмж /сая. төг/



### 1.8 Гэмт хэрэг


Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр 2019 онд 550 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 222 хүн гэмтэж, 24 хүн нас барсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 33 (6.4%)-аар, гэмтсэн хүний тоо 72 (48.0%) -оор нэмэгдэж, нас барсан хүний тоо 3 (11.1%)-аар буурсан байна.

Зураг. Гэмт хэргийн улмаас гэмтэж бэртсэн, нас барсан хүний тоо, жил бүрийн оны эцэст



Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хүний өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 4 (1.8%)-өөр, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 4 (40.0%)-өөр, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг 3 (75.0%)-аар, нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 9 (64.3%)-өөр, үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 21 (95.5%)-ээр буурч бусад төрлийн гэмт хэрэг нэмэгджээ.

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сараар




Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 39.1 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 30.7 хувийг хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг, 8.0 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, 22.2 хувийг бусад төрлийн гэмт хэргүүд эзэлж байна.

Согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 179 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 109 (2.5 дахин)-өөр нэмэгдсэн байна.

Гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс Айраг, Мандах, Сайхандулаан, Хатанбулаг, Улаанбадрах, Хөвсгөл, Замын-үүд сумдад буурч, бусад сумдад гэмт хэргийн тоо нэмэгдсэн байна.

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сумаар




Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 3558.9 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1257.9 (54.7 %) сая төгрөгөөр өссөн байна. Учирсан хохирлын 1972.2 (55.4%) сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

Нийт гэмт хэргийн 181 (32.9%) нь гэр орон сууцандаа, 179 (32.5%) нь согтуугаар, 62 (11.3%) нь гудамж олон нийтийн газарт, 54 (9.8%) бүлэглэн, 79 (14.4%) хувийг эмэгтэй хүн, хүүхэд оролцон, 177 (32.2%) нь шөнийн цагаар /22-06 цаг/ үйлдсэн байна.

Тайлант хугацаанд нийт 1569 хүн саатуулагдаж, 284 хүн баривчлагджээ.

*Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц, хэрэг үйлдэгдсэн цагаар 2019 оны эцэст*



## Хоёр. Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт




### 2.1 Дотоодын нийт бүтээгдэхүүн

Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) тооцоог 2007 оноос Сангийн сайд, ҮСГ-ын даргын 2006 оны 129\376 тоот тушаалаар батлагдсан эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын шинэчилсэн ангилалын дагуу 19 салбараар тооцож байна.

2018 онд ДНБ 369.2 тэрбум төгрөг /оны үнээр/ болж 2017 оныхоос 24.7 хувиар буюу 73.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 42.2 хувиар, үйлдвэрлэлийн салбар 44.5 хувиар, үйлчилгээний салбар 9.9 хувиар тус тус өслөө. Нэг хүнд ногдох ДНБ 2018 онд 5320.0 мянган төгрөгт хүрч өмнөх оноос 979.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн.



Зураг. Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн, мян төгрөгөөр




ДНБ-ийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл хөдөө аж ахуйн салбарт 116.2 (31.5%) тэрбум төгрөг, аж үйлдвэр, барилгын салбарт 72.9 (19.8%) тэрбум төгрөг, үйлчилгээний салбарт 180.1 (48.7%) тэрбум төгрөгийг тус тус үйлдвэрлэжээ.




## 2.2 Мөнгө, банк

Монгол банкны мэдээгээр арилжааны банкуудын зээлдэгчийн тоо 35.9 мянга болж өмнөх оноос 4.6(14.7%) мянган хүнээр нэмэгдэж, нийт хадгаламж эзэмшигчийн тоо 72.6 мянга болж өмнөх оны мөн үеээс 0.8 хувиар өссөн байна.

Зураг. Хадгаламж эзэмшигч, зээлдэгчийн тоо, 2018-2019 он, мян.хүн



Зураг. Хадгаламжийн үлдэгдэл, зээлийн өрийн үлдэгдэл, 2018-2019 он, сая.төг




Иргэдийн мөнгөн хадгаламж 113.9 тэрбум төгрөг болж нэг хадгаламж эзэмшигчид дунджаар 1638.9 мянган төгрөг, аймгийн нэг хүнд дундажаар 1709.5 мянган төгрөгийн хадгаламж ногдож байна. Хадгаламжийн үлдэгдлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.7 (5.3%) тэрбум төгрөгөөр өссөн байна.


Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 2019 оны 12 дугаар сарын эцэст 4.7 тэр бум төгрөг болж, өмнөх сараас 1.1(19.3%) тэр бум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 2.7(2.4<sup>2</sup>) тэр бум төгрөгөөр өсчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 1.6 хувийг эзэлж, өмнөх сараас 0.4 пунктээр буурч, өмнөх оны мөн үеэс 0.9 пунктээр өсчээ.

Чанаргүй зээл 12 дугаар сарын эцэст 7282.2 сая төгрөг болж өмнөх сараас 120.7(1.6%) сая төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 348.0(5.0%) сая төгрөгөөр өсч байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 3.0 хувийг эзэлж байна.

Зураг. Зээл төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2019 оны эцэст



Зураг. Зээлдэгчийн тоо, зээлийн төрлөөр, 2019 оны эцэст






### 2.3 Төсөв, санхүү

2019 оны 12 дугаар сарын байдлаар орон нутгийн төсөвт 79334.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 109.1 хувь байна. Өмнөх оны мөн үетэй төсвийн орлогын дүнг харьцуулахад 2.7 дахин өссөн байгаа нь 2018 оны орон нутгийн төсвийн орлогод улсын төсөв, орон нутгийн төсөв хоорондын шилжүүлсэн орлогын дүн тусгагдаагүй байсантай холбоотой юм. Аймгийн орон нутгийн төсвийн орлогын 34.9 хувийг татварын, 19.5 хувийг татварын бус орлого, 45.6 хувийг улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлсэн орлого бүрдүүлсэн байна.

*Зураг. Орон нутгийн төсвийн орлого, зарлагын бүтэц, хувиар, 2019 оны 12-р сард*



Улсын нэгдсэн төсөвт ААНБ-ын орлогын албан татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, ашигт малтмал нөөц ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр нийт 9994.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын дүнг өмнөх оны мөн үеэс 3840.7 (62.4%) сая.төг-өөр, төлөвлөгөөнөөс 4204.5 (72.6 %) сая.төг-өөр давуулан биелүүлсэн байна.



### 2.4 Үнэ

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний үнийн индекс 2019 оны 12 дугаар сарыг өмнөх сартай харьцуулахад 1.4 хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 5.9 хувиар өсчээ.

**Ерөнхий индекс өмнөх сартай харьцуулахад 1.4 хувиар өсөхөд:** хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 2.8 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлэг 0.9 хувь, хувцас бөс бараа, гутал 2.1 хувь, гэр ахуйн тавилгын бүлэг 1.7 хувь, эм тариа эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 0.7 хувь, тээврийн бүлэг 0.6 хувь, амралт чөлөөт цаг соёлын барааны бүлэг 0.1 хувь, зочид буудал, зоогийн газар, дотуур байрны үйлчилгээний бүлэг 3.4 хувь, бусад бараа үйлчилгээний үнэ 0.1 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2019 оны 12 дугаар сарын өөрчлөлт, бүлгээр, хувиар (өмнөх сар=100)




**Ерөнхий индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.9 хувиар өсөхөд:** хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 11.2 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлэг 4.3 хувь, хувцас бөс бараа, гуталын бүлэг 6.6 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг 6.9 хувь, гэр ахуйн тавилгын бүлэг 4.8 хувь, эм тариа эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 0.6 хувь, амралт чөлөөт цаг соёлын барааны бүлэг 2.9 хувь, боловсролын үйлчилгээний бүлэг 9.9 хувь, зочид буудал, зоогийн газар, дотуур байрны үйлчилгээний бүлэг 12.3 хувь, бусад бараа үйлчилгээний үнэ 3.8 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2018 - 2019 оны сар бүрээр (өмнөх сар=100)






Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2018-2019 оны 1-12 сарын үнийн өөрчлөлт (өмнөх сар=100)



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2015 -2019 оны 12 дугаар сар (өмнөх оны 12-р сар=100)



### Гурав. Эдийн засгийн статистикийн үзүүлэлт



#### 3.1 Хөдөө аж ахуй


2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр 2404.2 мянган толгой мал тоологдсоны дотор 43.5 мянган тэмээ, 152.6 мянган адуу, 91.9 мянган үхэр, 1021.6 мянган хонь, 1094.6 мянган ямаа тоологджээ. Нийт малын тоо өмнөх оноос 11.9 хувь буюу 256.1 мянган толгойгоор өсчээ. Мал сүргийн тоог таван төрлөөр авч



үзвэл 698 (1.6%) тэмээгээр, 12631 (9.1%) адуугаар, 95455 (10.3%) хониор, 11315 (14.0%) үхрээр, 136017 (14.2%) ямаагаар тус тус өссөн байна.


Жил бүрийн эцсийн мал тооллогын дүнг харахад аймаг байгуулагдсан 1931 оноос нэг саяас дээш мал тоолуулсан 26 дахь жил, хоёр сая мал тоолуулсан 3 дахь жил байлаа.

Зураг . Нэг саяас дээш толгой мал тоолуулсан он, малын тоо, мянган.толгой



Сүргийн бүтцэд ямаа 45.5 хувийг, хонь 42.5 хувийг, үхэр 3.8 хувийг, адуу 6.3 хувийг, тэмээ 1.8 хувийг тус тус эзэлж байна. Өмнөх онтой харьцуулахад тэмээ, адууны эзлэх хувь 0.2 пунктээр, хонины эзлэх хувь 0.6 пунктээр тус тус буурч, үхэрний эзлэх хувь 0.1 пунктээр, ямааны эзлэх хувь 0.9 пунктээр тус тус нэмэгдсэн байна.

Зураг. Мал сүргийн бүтэц, хувиар



Аймгийн хэмжээгээр 1000–аас дээш малтай өрхийн тоо 583 болж өмнөх оноос 138 өрхөөр өсчээ. 1000 –аас дээш малтай өрх Сайхандулаан суманд 65, Дэлгэрэх суманд 64, Өргөн суманд 53, Даланжаргалан суманд 51, Иххэт суманд 50


тоологдсон нь хамгийн олон нь байсан бол 2001-ээс дээш малтай өрх Дэлгэрэх суманд 8, Өргөн сумдад 7, Айраг, Сайхандулаан сумдад тус бүр 5 өрх, Иххэт, Мандах, хөвсгөл сумдад тус бүр 3, Даланжаргалан, Сайншанд сумдад тус бүр 2, Замын-Үүд, Алтанширээ, Хатанбулаг сумдад тус бүр 1 өрх тоологджээ.

Аминдаа малтай 5351 өрх байгаагийн 79.1 хувь буюу 4231 нь жилийн дөрвөн улирлын туршид малаа маллаж байгаа малчин өрх байна. Малчин нэг өрхөд 518, малтай нэг өрхөд 440 толгой мал ногдож байгаа нь 2018 оноос малчин нэг өрхөд ногдох мал 50 толгой, малтай нэг өрхөд ногдох мал 40 толгой малаар нэмэгджээ. Малчдын тоо 2019 онд 7024 болж өмнөх оноос 9 (0.1%)–аар буурчээ.

2019 онд оны эхний нийт хээлтэгч малын 759.6 (81.7%) мянган эх мал төллөж, гарсан төлийн 760.3 (98.9%) мянган төл бойжуулжээ. Үүнийг өмнөх онтой харьцуулахад бойжсон төл 15.2 хувиар өссөн байна.

2019 онд 8.6 мянган толгой мал зүй бусаар хорогдсон нь оны эхний малын 0.4 хувьтай тэнцэж байна. Сайхандулаан, Мандах, Хөвсгөл, Дэлгэрэх сумдад хорогдсон малын тоо нь нийт хорогдлын 66.3 хувийг эзэлж байна.

Зураг. Том малын зүй бусын хорогдол, мянган толгойгоор, 2000-2019 он



Энэ онд 63 худаг шинээр гаргахад 878.1 сая төгрөг, 275 худаг сэргээн засварлахад 80.8 сая төгрөг зарцуулсан байна.

Малжуулах арга хэмжээнд 90 өрхийг хамруулж нийт 5981 толгой мал олгосны 99.4 хувь нь бог мал байв. Малжуулалтанд хамрагдсан өрхийн тоо өмнөх оныхоос 14 (13.5%) өрхөөр буурсан. Нэг өрхөд дундажаар 66 толгой мал ногдож байгаа нь өмнөх оныхоос 20 толгойгоор буурсан үзүүлэлт байна.

Нийт малчин өрхийн 84.5 хувь нь цахилгааны эх үүсгүүртэй, 77.2 хувь нь телевизортэй, 62.1 хувь нь автомашинтай, 70.9 хувь нь мотоциклтой өрх байна. Өмнөх оныхоос цахилгааны эх үүсгүүртэй өрх 6.1 пункт, телевизортой өрх 6.6 пункт, автомашинтай өрх 8.4 пункт, мотоциклтой өрх 9.3 пунктээр тус тус өссөн байна.

2019 онд 15.3 га талбайд төмс, 48.6 га-д хүнсний ногоо тариалж, 85.8 тн төмс, 223.5 тн хүнсний ногоо хураан авлаа. Өмнөх оныхоос хураан авсан төмс 8.1 тн-



оор, хүнсний ногоо 11.0 тн-оор тус тус буурсан байна. 1 га-аас 4.8 тонн төмс, хүнсний ногоо хураан авсан нь 2018 оноос 0.6 тн-оор нэмэгджээ. Тайлант онд 7752.0 тн өвс хадлан, 219.4 тн гар тэжээл, 409.4 тн хужир шүү тэжээл бэлтгэсэн мэдээ ирүүлснийг өмнөх онтой харьцуулахад бэлтгэсэн өвс 35.4 хувиар нэмэгдэж, гар тэжээл 55.4 хувиар, хужир шүү 25.3 хувиар тус тус буурчээ.



### 3.2 Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарт оны эхний 12 сард оны үнээр 195674.8 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 298768.0 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлууллаа. Өмнө онтой харьцуулахад нийт бүтээгдэхүүн үйлвэрлэлт 18158.4(8.5%) сая төгрөгөөр, борлуулалт 22114.8(6.9%) сая төгрөгөөр тус тус буурчээ.

Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр авч үзвэл улсын үйлдвэрийн газар 3.9 хувь, компани 95.7 хувь, өрхийн аж ахуй 0.4 хувийг тус тус үйлдвэрлэжээ. Сүүлийн жилүүдэд нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн дийлэнх хувийг хувийн компани эзлэж байгаа нь уул уурхай болон боловсруулах салбарын мэдээлэгч нэмэгдэж байгаатай холбоотой юм.

Статистикийн мэдээлэлд хамрагдсан гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өмнөх оны мөн үетэй харьцуулахад дулаан 62.9 мян.ккал-аар, сувагжуулалт 85.4 мян.м<sup>3</sup>-аар, ус түгээлт 104.9 мян.м<sup>3</sup>-аар, хайрга 6.9 мян.м<sup>3</sup>-аар, талх 31.9 тонноор, хиам 8.0 тонноор, жижиг төмөр эдлэл 5410.0 мян.төгрөгөөр, дээл 109 ширхгээр, 8289.6 м<sup>3</sup>-аар, савласан цэвэр ус 458.7 мян.литрээр, цемент 80.4 мян.тонноор, сүүн бүтээгдэхүүн 12.5 мян.литрээр, хэрчсэн гурил 8.7 мян.тонноор, бетон зуурмаг 8289.6 м<sup>3</sup>-аар, цемент 80.4 мян.тонноор тус тус илүү үйлдвэрлэгджээ.



### 3.3 Тээвэр, Холбоо

2019 онд 184.3 мянган тонн ачаа тээвэрлэж, 54521.1 мянган тонн км-ын ажил, 50.0 мянган зорчигч тээвэрлэж, 15204.0 мянган хүн,км-ын ажил гүйцэтгэсэн байна. Тээвэрлэлтийн нийт орлого 12016.3 сая төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 13.1 хувиар өссөн байна.

2019 онд хийгдсэн тээврийн хэрэгслийн техникийн хяналт оношлогооны мэдээгээр тээврийн хэрэгслийн бүртгэлийн санд 23844 авто машин, тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн нь өмнөх оноос 33.1 хувь буюу 5.9 мянгаар нэмэгджээ. Нийт тээврийн хэрэгслийн 89.2 хувийг автомашин, 4.1 хувийг мотоцикл, 6.0 хувийг чиргүүл эзэлж байна.

2019 онд 10109 тээврийн хэрэгсэл үзлэг оношлогоонд хамрагдаж, тээврийн хэрэгслийн бүртгэлийн санд бүртгэлтэй тээврийн хэрэгсэлийн 42.4 хувь нь үзлэгт хамрагдсан байна.

Шуудан холбооны үйлчилгээний орлого 520.5 сая төгрөг болж өмнөх оноос 0.5 хувиар өссөн байна. Суурин телефон цэгийн тоо 2019 онд 2046 болж өмнөх оноос 9.7 хувиар буюу 182 хэрэглэгчээр өссөн байна. Энэ онд нийт 13.1 мянган





ширхэг албан бичиг, захидал 4.0 мянган ширхэг, 724 ширхэг илгээмж (боодол) илгээж, 44.8 сая төгрөгийн орлого оруулжээ.

Аймгийн хэмжээнд 2 кабелийн болон эфирийн телевиз 1540 гаруй хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлж, нийт 113.8 сая төгрөгийн орлоготой ажиллажээ. Байршлаар нь авч үзвэл Сайншанд суманд 1, Замын-Үүд суманд 1 кабелийн телевизийн цэг ажиллаж байна.

2019 онд Дорноговь аймагт үүрэн телефоны оператор 4 компанийн салбар ажиллаж байгааг байршлаар авч үзвэл юнителын 15, мобикомын 15, скайтелын 13, G-mobile 12, суурин телефон цэг 7 суурин газарт нийт 62 салбар нэгж сум, суурин газруудад үйлчилгээ үзүүлжээ. Үүрэн телефоны салбарууд энэ онд нийт 7590.0 сая төгрөгийн орлоготой ажилласан нь өмнөх оныхоос 13.3 хувиар өссөн байна. Үүрэн телефон хэрэглэгчдийн тоо (давхардсан тоогоор) 102.6 мянга орчим байгаа нь өмнөх оноос 0.7 мянган хэрэглэгчээр нэмэгдсэн байна.

## Дөрөв. Байгаль орчны статистикийн үзүүлэлт



### 4.1 Байгаль орчин

#### Цаг уур

Сарын дундаж агаарын температур: Хатанбулаг, Хөвсгөл, Улаанбадрах сумдад 10.3-11.7 градус хүйтэн, бусад сумдын нутгаар 12.0-16.0 градус хүйтэн, агаарын хамгийн бага температур шөнөдөө Сайншанд, Эрдэнэ, Айраг, Алтанширээ, Иххэт сумдад 30-32 градус хүйтэн, бусад сумдын нутгаар 26-29 градус хүйтэн байлаа. Агаарын дундаж температурыг олон жилийн дундаж /ОЖД/-тай харьцуулахад: Сайншанд, Эрдэнэ сумдад ОЖД-ийн орчим, бусад сумдын нутгаар ОЖД-аас дулаан байлаа. Хөрсний гадарга дээр шөнөдөө 28-33 градус хүйтэн, өдөртөө нийт сумдын нутгаар 3-9 градус дулаан байв.

Хур тунадас: 12 дугаар сард нийт сумдын нутгаар 3-8 өдөр цас орж, сарын нийлбэр хамгийн их тунадас Алтанширээ суманд 5.1 мм, бусад сумдын нутгаар 0.8-4.8 мм орлоо. Орсон хур тунадасны нийлбэрийг олон жилийн дундаж /ОЖД/-тай харьцуулахад: Улаанбадрах суманд ОЖД-аас бага, Сайншанд, Мандах, Хөвсгөл сумдад ОЖД-ийн орчим, бусад сумдад ОЖД-аас ахиу байв.

Салхи: Энэ сард салхины хамгийн их хурд Айраг, Алтанширээ, Өргөн, Улаанбадрах, Хатанбулаг сумдад секундэд 8-9 метр, бусад сумдад секундэд 10-14 метр хүрч 10 м/с-ээс дээш салхитай 3...14 өдөр байлаа.

Цасан бүрхүүлийн байдал: 12 дугаар сарын сүүлийн арав хоногийн байдлаар Эрдэнэ, Өргөн, Алтанширээ, Иххэт сумдад 10 баллын 1...13 см, бусад сумдын нутгаар 1...9 баллын 0...4 см зузаан цасан бүрхүүлтэй байна. Цасны дундаж нягт Эрдэнэ, Дэлгэрэх, Айраг, Алтанширээ сумдад 0.15-0.18 г/см<sup>3</sup>, Иххэт суманд 0.24 г/см<sup>3</sup> байв.

\_\_\_\_\_ о О о \_\_\_\_\_



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**  
( 2019 ОНЫ 12 ДУГААР САРЫН БАЙДЛААР )

**I. Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүд**

	Хэмжих нэгж	2016	2017	2018	2019	2019 2018
1. Бэлэн хүн ам, мян.хүн *	мянган хүн	66.6	68.2	69.6	71.0	102.0
- Төрсөн хүүхдийн тоо**	тоо	1436	1325	1371	1358	99.1
- Нас барсан хүний тоо - бодит тоогоор**	тоо	391	340	402	399	99.3
- Хүн амын цэвэр өсөлт - бодит тоогоор	тоо	1136	1026	969	959	99.0
- Нялхасын эндэгдэл - бодит тоогоор	тоо	19	17	16	10	62.5
- 1000 хүүхдэд ноогдох	тоо	11.4	12.3	11.7	7.4	63.1
2. Ажилгүй иргэдийн тоо - бүгд	тоо	1 503	1 025	993	300	30.2
- Үүнээс эмэгтэй	тоо	811	530	497	144	29.0
- Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүй иргэдийн тоо	тоо	354	237	230	69	30.2
3. Шинээр бий болсон ажлын байр-бүгд	тоо	459	810	1020	1103	108.1
Үүнээс: Байнгын ажлын байр	тоо	349	580	746	536	71.8
Улирлын чанартай ажлын байр	тоо	110	230	274	567	2.0 <sup>2</sup>
4. Халдварт өвчний гаралт - бодит тоогоор	тоо	1742	687	737	1119	151.8
- 10000 хүнд ногдох	тоо	262	101	106	160	151.3
5. Гэмт хэргийн гаралт - бодит тоогоор	тоо	665	654	517	550	106.4
- 10000 хүнд ногдох ***	тоо	155	149	117	124	105.5
8. Малын тоо						
- Бүгд	мян. толгой	1752.9	2001.6	2148.1	2404.2	111.9
- Тэмээ	мян. толгой	37.7	40.7	42.8	43.5	101.6
- Адуу	мян. толгой	118.7	133.2	139.9	152.6	109.1
- Үхэр	мян. толгой	63.0	72.6	80.6	91.9	114.0
- Хонь	мян. толгой	758.4	861.5	926.2	1021.6	110.3
- Ямаа	мян. толгой	775.2	893.6	958.6	1094.6	114.2
7. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая төгрөг	35998.5	162252.1	213833.2	195674.8	91.5
- Борлуулсан бүтээгдэхүүн	сая төгрөг	55132.1	273507.2	320882.8	298768.0	93.1

\* - 2016,2017,2018 оны жилийн эцэст, 2019 он урьдчилсан дүн

\*\*-Төрөлт, нас баралтыг ЭМГ-ын мэдээнээс авав.

\*\*\* - 18 - аас дээш насны 10000 хүнд ногдохоор тооцов.



НЭГ. ХҮН АМ

1.1 СУУРИН ХҮН АМЫН ТОО, сумаар, оны эцэст

	2015	2016	2017	2018	2019*	2019 2015	2019 2018
	ХҮН					ХУВЬ	
<b>Бүгд</b>	<b>63125</b>	<b>66606</b>	<b>68192</b>	<b>69560</b>	<b>70975</b>	<b>112.4</b>	<b>102.0</b>
Айраг	3612	3738	3811	3766	3714	102.8	98.6
Алтанширээ	1262	1294	1327	1360	1336	105.9	98.2
Даланжаргалан	2680	2742	2749	2895	2982	111.3	103.0
Дэлгэрэх	1851	1889	1873	1840	1832	99.0	99.6
Иххэт	2039	2077	2108	2112	2102	103.1	99.5
Мандах	1566	1568	1587	1596	1566	100.0	98.1
Өргөн	1889	1933	2004	2076	2123	112.4	102.3
Сайхандулаан	1292	1367	1380	1378	1387	107.4	100.7
Улаанбадрах	1431	1474	1470	1482	1485	103.8	100.2
Хатанбулаг	2752	2941	2919	2872	2854	103.7	99.4
Хөвсгөл	1518	1568	1573	1540	1556	102.5	101.0
Эрдэнэ	2340	2437	2378	2439	2383	101.8	97.7
Сайншанд	23191	24059	24772	25274	26405	113.9	104.5
Замын-Үүд	15702	17519	18241	18930	19250	122.6	101.7

Тайлбар \* -урьдчилсан дүнгээр

1.2 ХҮН АМЫН ТОО, сумаар, насны ангиллаар, 2019\* онд

	Хүүхэд 0-14 нас	Хөдөлмөрийн нас	Тэтгэврийн нас 60<	Үүнээс: 85 < настай
<b>Бүгд</b>	<b>22452</b>	<b>43957</b>	<b>4566</b>	<b>163</b>
Айраг	1128	2334	252	18
Алтанширээ	354	858	124	4
Даланжаргалан	915	1872	195	4
Дэлгэрэх	532	1163	137	6
Иххэт	609	1290	203	4
Мандах	437	986	143	4
Өргөн	604	1369	150	6
Сайхандулаан	426	872	89	3
Улаанбадрах	405	921	159	6
Хатанбулаг	796	1859	199	8
Хөвсгөл	433	998	125	6
Эрдэнэ	721	1481	181	7
Сайншанд	8672	15776	652	17
Замын-Үүд	6420	12178	1957	70



1.3 ӨРХИЙН НИЙГМИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, сумаар, оны эцэст

	2 ихэр хүүхэдтэй өрх		5 хүүхэдтэй өрх		6 хүүхэдтэй өрх		7, түүнээс дээш хүүхэдтэй өрх	
	2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019
	Тоо							
Бүгд	232	230	107	110	25	15	2	13
Айраг	13	14	5	9	2	1		
Алтанширээ	4	2	3	1	1	0		9
Даланжаргалан	7	8	4	7	4	1		1
Дэлгэрэх	7	8	3	7	0	1		
Иххэт	10	11	5	6	1	1		
Мандах	4	4	4	6	1	0		
Өргөн	9	8	2	2	0	0		
Сайхандулаан	5	6	1	3	0	0		
Улаанбадрах	1	1	1	2	0	0		
Хатанбулаг	9	10	11	7	1	0		
Хөвсгөл	8	7	3	0	1	1		
Эрдэнэ	7	7	1	1	0	0		1
Сайншанд	93	91	39	41	11	6	2	2
Замын - Үүд	55	53	25	18	3	4		

	Тэтгэвэр тэтгэмж тогтоогдоогүй ахмад настай хүний тоо		Ганц биеэрээ амьдарч байгаа өндөр настан өрхийн тоо		Эмэгтэй тэргүүлэгчтэй өрх		Гэр бүлгүй өрх толгойлсон эрэгтэй	
	2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019
	хүн							
Бүгд	20	7	1053	1017	2001	1741	367	309
Айраг			66	73	184	203	39	52
Алтанширээ			21	44	35	33	7	10
Даланжаргалан			74	75	75	67	24	14
Дэлгэрэх	1		39	37	68	52	20	6
Иххэт			57	59	118	105	41	28
Мандах			34	41	47	54	16	21
Өргөн	2		45	41	89	85	35	37
Сайхандулаан			55	26	34	21	12	4
Улаанбадрах	1		34	36	46	28	6	3
Хатанбулаг		2	62	48	90	64	14	4
Хөвсгөл			28	30	55	55	11	2
Эрдэнэ	2	2	49	58	89	92	31	32
Сайншанд	12	3	396	316	957	775	99	80
Замын - Үүд	2		93	133	114	107	12	16



1.4 ХҮН АМЫН НИЙГМИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, сумаар, оны эцэст

	Бүтэн өнчин хүүхэд				Хагас өнчин хүүхэд			
	2016	2017	2018	2019	2016	2017	2018	2019
хүн								
Бүгд	60	54	54	54	695	748	780	797
Айраг	2	1	2	5	83	75	70	87
Алтанширээ	0	0	2	1	13	19	20	18
Даланжаргалан	1	1	1	1	28	34	37	42
Дэлгэрэх					14	11	12	10
Иххэт	4	6	6	4	22	25	26	26
Мандах	1	1	1	2	22	21	18	15
Өргөн	3	2	2	1	13	11	19	17
Сайхандулаан	1	0		1	11	9	11	12
Улаанбадрах	0	0		1	17	17	23	19
Хатанбулаг			1	1	48	33	36	27
Хөвсгөл					25	21	24	27
Эрдэнэ	4	3	3	2	19	15	17	19
Сайншанд	24	24	21	24	238	271	279	288
Замын - Үүд	20	16	15	11	142	186	188	190

	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо				0-14 насны хугжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо			
	2016	2017	2018	2019	2016	2017	2018	2019
хүн								
Бүгд	2470	2552	2559	2642	214	197	206	209
Айраг	196	215	184	209	8	6	8	7
Алтанширээ	58	66	46	65	6	6	7	7
Даланжаргалан	96	83	93	86	13	8	10	10
Дэлгэрэх	71	69	65	76	4	2	3	3
Иххэт	155	166	157	153	10	9	8	9
Мандах	75	65	67	74	10	10	10	10
Өргөн	93	93	87	95	3	3	4	4
Сайхандулаан	56	49	62	59	8	8	6	3
Улаанбадрах	60	55	34	50	4	6	3	1
Хатанбулаг	120	113	90	91	15	8	3	5
Хөвсгөл	61	53	72	69	2	0	1	1
Эрдэнэ	72	124	114	140	9	10	10	14
Сайншанд	993	988	1021	989	79	75	84	89
Замын - Үүд	364	413	467	486	43	46	49	46



## ХОЁР. ЭРҮҮЛ МЭНД

## 2.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ

	Хэмжих нэгж	2018	2019	Өсөлт	
		Тоо		Хувь	
1.Амбулаторийн үзлэг бүгд	мян.хүн	353.7	411.0	57.3	116.2
Үүнээс: Нэгдсэн эмнэлэг (СШ)	мян.хүн	119.6	126.3	6.7	105.6
Сумын эмнэлэг	мян.хүн	135.6	163.7	28.1	120.7
Монгол уламжлалт эмнэлэг	мян.хүн	3.3	3.4	0.1	103.0
Цэргийн эмнэлэг	мян.хүн	5.6	6.4	0.8	2.4 <sup>2</sup>
Хувийн хэвшлийн эмнэлэг	мян.хүн	24.5	23.9	-0.6	97.6
Өрхийн эмнэлэг	мян.хүн	65.1	81.2	16.1	124.7
Төмөр замын эмнэлэг	мян.хүн		6.1		
2.Ор хоног бүгд	мян.хүн	120.6	123.3	2.7	102.2
Үүнээс: Нэгдсэн эмнэлэг (СШ)	мян.хүн	51.4	52	0.6	101.2
Сумын эмнэлэг	мян.хүн	38.9	41.8	2.9	107.5
Монгол уламжлалт эмнэлэг	мян.хүн	9.4	9.2	-0.2	97.9
Цэргийн эмнэлэг	мян.хүн	0.2	0.1	-0.1	0.0
Хувийн хэвшлийн эмнэлэг	мян.хүн	20.7	20.2	-0.5	97.6
3.У.С.Тарилга бүгд	мян.хүн	13.1	13.3	0.2	101.5
Үүнээс: Нэгдсэн эмнэлэг (СШ)	мян.хүн	2.2	2.2	0.0	100.0
Сумын эмнэлэг	мян.хүн	4.2	4	-0.2	95.2
Өрхийн эмнэлэг	мян.хүн	6.7	7.1	0.4	106.0
4.Эмчлүүлсэн хүний тоо бүгд	мян.хүн	17.0	17.4	0.4	102.6
Үүнээс: Нэгдсэн эмнэлэг (СШ)	мян.хүн	7.7	7.8	0.1	101.3
Сумын эмнэлэг	мян.хүн	5.6	6	0.4	107.1
Монгол уламжлалт эмнэлэг	мян.хүн	1	1	0.0	100.0
Цэргийн эмнэлэг	мян.хүн	0.07	0.01	-0.1	0.0
Хувийн хэвшлийн эмнэлэг	мян.хүн	2.6	2.6	0.0	100.0
5.Халдварт өвчний гаралт бүгд	хүн	737	1119	382	151.8
Үүнээс: Сумын эмнэлэг	хүн	214	455	241.0	212.6
Нэгдсэн эмнэлэг	хүн	404	539	135.0	133.4
Өрхийн эмнэлэг	хүн	30	29	-1.0	96.7
Хувийн эмнэлэг	хүн	88	96	8.0	109.1
Цэргийн эмнэлэг	хүн	1	0	1	0.0
6.Нялхсын эндэгдэл бүгд	хүн	16	10	-6.0	62.5
Үүнээс: Нэгдсэн эмнэлэг	хүн	8	7	-1.0	87.5
Сумын эмнэлэг	хүн	6	1	-5.0	16.7
Өрхийн эмнэлэг	хүн	2	2	0.0	100.0
7.Түргэн тусламжийн дуудлага	мян.хүн	19.7	20.1	0.4	102.0
Үүнээс: алсын дуудлага	мян.хүн	3.1	2.9	-0.2	93.5
8.Осол гэмтлийн өвчлөл	хүн	3016	3376	360.0	111.9
Үүнээс: нас баралт	хүн	107	97	-10	90.7
9.Шинээр хяналтанд авсан жирэмсэн эх	хүн	1630	1811	181.0	111.1
Үүнээс: эхний 3 сартайн хяналт	хүн	1450	1604	154.0	110.6

Тайлбар - <sup>2</sup> дахин их

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар





## 2.2. ТӨРӨЛТ, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар, жил бүрийн 12 сард

Сумын нэр	Амаржсан эх	Эхийн эндэгдэл	Амьд төрсөн хүүхэд	1 хүртэл насандаа эндсэ	1-5 хүртэл насны эндсэн хүүхэд
	Тоо				
Дүн	1351	0	1358	10	7
Айраг	2		2		1
Алтанширээ	1		1		
Даланжаргалан	2		2		1
Дэлгэрэх	1		1		
Иххэт					
Мандах					
Өргөн	2		2		3
Сайхандулаан	1				
Улаанбадрах					
Хатанбулаг	4		4	1	
Хөвсгөл	2		2		
Эрдэнэ	2		2		
Сайншанд	1082		1091	9	2
Замын - Үүд	252		251		

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

## 2.3. БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, төрлөөр, жил бүрийн 12 сард

Үзүүлэлт	2018 I-XI	2019 I-XI	Өсөлт	
	Тоо		Тоо	Хувь
Халдварт өвчний гаралт-Бүгд	737	1119	382	151.8
Вируст гепатит	9	6	-3	66.7
Сүрьеэ	100	86	-14	86.0
Тэмбүү	124	192	68	154.8
Заг хүйтэн	192	311	119	162.0
Трихоминиаз	94	160	66	170.2
Цусан суулга	55	41	-14	74.5
Бусад	163	323	160	198.2

Тайлбар -<sup>2</sup>-дахин их

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар



2.4 ЭМНЭЛЭГТ ХЭВТЭЖ ЭМЧЛҮҮЛСЭН ХҮНИЙ ТОО, сумаар

	2015 I-XII	2016 I-XII	2017 I-XII	2018 I-XII	2019 I-XII	2019 I-XII	2019 I-XII
						2015 I-XII	2018 I-XII
БҮГД	13578	15406	16054	16900	17375	128.0	102.8
Айраг	287	346	284	361	282	98.3	78.1
Алтанширээ	200	199	224	203	170	85.0	83.7
Даланжаргалан	181	246	229	215	230	127.1	107.0
Дэлгэрэх	181	171	180	178	143	79.0	80.3
Иххэт	210	266	260	240	197	93.8	82.1
Мандах	201	253	202	179	194	96.5	108.4
Өргөн	189	180	188	169	176	93.1	104.1
Сайхандулаан	141	135	139	136	149	105.7	109.6
Улаанбадрах	196	189	205	203	203	103.6	100.0
Хатанбулаг	216	272	240	233	302	139.8	129.6
Хөвсгөл	172	149	102	126	118	68.6	93.7
Эрдэнэ	205	217	217	224	244	119.0	108.9
Зүүнбаян	244	251	291	315	302	123.8	95.9
Замын-Үүд	2234	2805	2694	2812	3248	145.4	115.5
Нэгдсэн Эмнэлэг	7145	7812	7363	7673	7810	109.3	101.8
Төмөр зам							
УАУТ	570	679	988	1049	1021	179.1	97.3
Улаан-уул	21	8		12	5	23.8	41.7
ЗБЦА	0	0					
Сулинхээр	7	15	6	15	5	71.4	33.3
Ачлал	434	478	516	533	539	124.2	101.1
Идэр-Өлзийт	446	577	840	824	723	162.1	87.7
Тэнгэрийн ивээл	98	158	141	153	154		100.7
Шонхор мед			223	385	426		110.6
Ач үйлс дэлгэр			522	662	734		110.9

Тайлбар-<sup>2</sup> дахин их

2.5 НЯЛХСЫН ЭНДЭГДЭЛ, амьд төрсөн 1000 хүүхэд тутамд ногдохоор, сумаар

	2015 I-XII	2016 I-XII	2017 I-XII	2018 I-XII	2019 I-XII	2019 I-XII	2019 I-XII	
						2015 I-XII	2018 I-XII	
	хувь					пункт		
БҮГД	11.4	13.8	12.3	7.4	7.4	-4.0	0.0	
Айраг	0.0	0.0	10.5	0.0	0.0	0.0	0.0	
Алтанширээ	0.0	31.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	
Даланжаргалан	0.0	15.6	0.0	0.0	0.0	0.0	0.0	
Дэлгэрэх	19.2	22.7	30.3	0.0	0.0	-19.2	0.0	
Иххэт	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	
Мандах	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	
Өргөн	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	
Сайхандулаан	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	
Улаанбадрах	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	
Хатанбулаг	0.0	16.4	0.0	0.0	250	250.0	250.0	
Хөвсгөл	0.0	0.0	28.6	0.0	0.0	0.0	0.0	
Эрдэнэ	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	
Сайншанд	23.5	27.3	18.8	8.2	8.2	-15.2	0.0	
Замын-Үүд	6.4	5.1	11.0	0.0	0.0	-6.4	0.0	

## ГУРАВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ

## 3.1 БҮХ ШАТНЫ СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД

	2016	2017	2018	2019	2019 2016	2019 2018
Суралцагч-Бүгд	13586	13983	14152	15201	111.9	107.4
Үүнээс:						
Ерөнхий боловсролын сургууль	12278	12759	13009	13971	113.8	107.4
Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв	623	597	577	755	121.2	130.8
Анагаахын шинжлэх ухааны үндэсний	685	627	566	475	69.3	83.9
Сургуулийн тоо-Бүгд	24	25	25	25	104.167	100
Үүнээс:						
Ерөнхий боловсролын сургууль	21	22	22	22	104.762	100
Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв	2	2	2	2	100	100
ЭМШУИС-ийн салбар сургууль	1	1	1	1	100	100

## 3.2 БҮХ ШАТНЫ СУРГУУЛЬД ЭЛСЭГЧИД

	2016	2017	2018	2019	2019 2016	2019 2018
Элсэгч-Бүгд	3080	3713	4207	4295	139.4	102.1
Ерөнхий боловсролын сургууль	2649	3212	3551	3645	137.6	102.6
Бага боловсролоор элсэгчид	1368	1553	1621	1655	121.0	102.1
Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв,	300	360	516	560	186.7	108.5
